



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны Журам батлах тухай 38 дугаар тогтоолын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, үнэлгээ өгөх Үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний багийн ахлагч:

Ж.Батжавхлан
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Өсөхбаяр
Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга
П.Сумъяасүрэн
Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт,
шинжилгээний хэлтсийн дарга/
Б.Отгонхүү
Тохижилт, нийтийн аж ахуйн
хэлтсийн дарга
О.Ариунболд
Хүнс, худалдаа, үйлчилгээний
хэлтсийн дарга
С.Сувд-Эрдэнэ
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Т.Амартогтох
Цэргийн штабын дарга, хошууч
Д.Балдансүрэн
Аж ахуйн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Г.Батцэцэг
Хүний нөөц, хөрөнгө орлогын
мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв, бодитой дүгнэж үнэлэхийг Үнэлгээний баг /Ж.Батжавхлан/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АМАРТҮВШИН